НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын Хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/556/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр<br>Утас: 325093 Цахим хаяг: Munkhdelgerd@audit.gov.mn<br>Аудитор: Б.Тэгшлхам<br>Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn |
| OBJ OBJ | OBJ OBJ |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....................................4

3. Байгууллага, түүний үйл ажиллагаа ........................................................................................13

**4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** .............13

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 150

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.МӨНХБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд дүүргийн ИТХ-аас 16.5 сая төгрөг, ЗДТГ-аас 68.3 сая төгрөг, нийслэлийн Соёл урлагийн газраас 8.6 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 43.6 сая төгрөг, нийт 137.1 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 135.8 сая төгрөг зарцуулж, 1.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 203.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 572.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй олгосон байна.

1426050149

**Бусад асуудал**

Тайлант онд гамшиг, осол эрсдэлээс урьдчилан сэрэмжлэх, эрэн хайх аврах үйл ажиллагаанд 130 дуудлага бүртгэж, 31 иргэний амь насыг авран хамгаалж, 4.3 сая төгрөгийн эд хөрөнгийг хохирлоос хамгаалж ажилласан байна. Өмнөх оноос дуудлагын мэдээлэл 72.1 хувиар буурч, аврах ажиллагаа 31.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 87.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тод-руулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,042,057,688.08** | **1,135,683,876.78** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4** | | - |
| **33** | **АВЛАГА** | **5** | 27,993.90 | - |
| **335** | **Бусад авлага** | | 27,993.90 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 27,993.90 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | - | 557,728.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | | - | 557,728.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | | - | 557,728.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | 1,042,029,694.18 | 1,135,126,148.78 |
| **351** | **Түүхий эд материал** | | 530,185,049.57 | 873,139,765.30 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 527,984,049.57 | 870,670,265.30 |
| 35130 | Эм боох материал | | 2,201,000.00 | 2,469,500.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | 271,172,658.00 | 79,171,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | | 240,671,986.61 | 182,815,383.48 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 2,054,590.50 | 1,787,050.50 |
| 35420 | Аж ахуйн материал | | 2,711,800.00 | 2,711,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 9,810,371.00 | 6,567,571.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 59,454,881.06 | 5,175,170.43 |
| 35450 | Барилгын засварын материал | | 4,032,000.00 | 4,132,100.00 |
| 35460 | Хүнсний материал | | 166,652.50 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 162,441,691.55 | 162,441,691.55 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **2,412,204,786.10** | **2,553,500,367.77** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | 2,412,204,786.10 | 2,553,500,367.77 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 2,028,463,736.10 | 2,169,759,317.77 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 830,154,055.42 | 805,559,619.42 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (198,611,881.98) | (201,976,987.11) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 4,413,745,483.44 | 3,399,067,722.44 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | (3,079,329,300.04) | (2,103,678,023.00) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 537,653,939.48 | 320,291,340.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (483,837,920.48) | (63,533,701.60) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 39,973,070.40 | 34,832,440.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (31,283,710.14) | (20,803,093.17) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 383,741,050.00 | 383,741,050.00 |
| 39301 | Програм хангамж | | 1,130,000.00 | 1,130,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,130,000.00) | (1,130,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 383,741,050.00 | 383,741,050.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **3,454,262,474.18** | **3,689,184,244.55** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **-** | **10,330,199.07** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9** | - | 10,330,199.07 |
| **413** | **Өглөг** | | - | 10,330,199.07 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | - | 10,330,199.07 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **3,454,262,474.18** | **3,678,854,045.48** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 3,454,262,474.18 | 3,678,854,045.48 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 665,573,641.94 | 665,573,641.94 |
| 51101 | Өмч: - төрийн | | 665,573,641.94 | 665,573,641.94 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 2,112,808,268.24 | 2,370,214,424.54 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 1,973,960,193.85 | 2,145,622,853.24 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 138,848,074.39 | 224,591,571.30 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 675,880,564.00 | 643,065,979.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **3,454,262,474.18** | **3,689,184,244.55** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тод-руулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2.0** | **2,723,414,429.35** | **3,619,954,422.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **682,653,935.35** | **1,167,224,417.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 682,653,935.35 | 1,167,224,417.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 682,653,935.35 | 1,167,224,417.10 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 682,653,935.35 | 1,167,224,417.10 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **2,040,760,494.00** | **2,452,730,005.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 1,932,802,100.00 | 2,315,669,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,932,802,100.00 | 2,315,669,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 107,958,394.00 | 137,060,205.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 39,091,474.00 | 68,267,115.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 66,866,920.00 | 59,962,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт | | 2,000,000.00 | 8,830,590.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3.0** | **2,584,566,354.96** | **3,395,362,850.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **2,584,566,354.96** | **3,395,362,850.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 2,534,855,801.45 | 3,378,681,968.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 1,625,806,992.98 | 1,975,074,723.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,625,806,992.98 | 1,970,680,523.00 |
| 210102 | Нэмэгдэл | | - | 4,394,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 36,187,083.40 | 43,584,331.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 4,544,850.00 | 794,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 522,913.00 | 49,756.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 5,238,505.00 | 1,869,358.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 104,583.00 | 9,951.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 25,776,232.40 | 40,860,766.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 65,582,594.39 | 119,895,499.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 12,829,564.39 | 22,773,437.75 |
| 210302 | Түлш, халаалт | | 40,359,850.00 | 87,287,775.32 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 12,393,180.00 | 9,834,286.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 121,069,188.33 | 195,307,858.60 |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,056,850.00 | 4,585,060.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 107,520,201.51 | 178,679,859.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,408,136.82 | 3,207,939.60 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | | 2,150,000.00 | 7,730,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,080,000.00 | 1,045,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | - | 60,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 76,383,097.50 | 434,264,382.50 |
| 210502 | Хоол, хүнс | | 76,383,097.50 | 114,188,109.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | - | 320,076,273.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 115,861,975.00 | 96,831,150.00 |
| 210604 | Урсгал засвар | | 115,861,975.00 | 96,831,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | - | 5,650,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | - | 5,650,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 4,720,095.00 | 27,652,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1,144,000.00 | 20,188,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 2,262,955.00 | 6,526,150.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 429,000.00 | 429,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 85,100.00 | 108,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 799,040.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 489,244,774.85 | 480,421,574.33 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 50,312,000.00 | 38,865,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 438,932,774.85 | 441,555,874.33 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 49,710,553.51 | 16,680,881.82 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 4,059,000.00 | 7,179,200.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | - | 5,039,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 4,059,000.00 | 2,140,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 45,651,553.51 | 9,501,681.82 |
| 213301 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 45,651,553.51 | 8,167,211.82 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | 1,334,470.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **138,848,074.39** | **224,591,571.30** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **138,702,074.39** | **224,591,571.30** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,040,760,494.00** | **2,452,730,005.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,038,760,494.00** | **2,443,899,415.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,932,802,100.00 | 2,315,669,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,932,802,100.00 | 2,315,669,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 105,958,394.00 | 128,229,615.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,091,474.00 | 68,267,115.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 66,866,920.00 | 59,962,500.00 |
| 131105 | Бусад нэмэлт орлого | 2,000,000.00 | 8,830,590.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,040,760,494.00** | **2,452,730,005.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,040,760,494.00** | **2,452,730,005.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,990,113,940.49** | **2,436,049,123.18** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,616,937,957.30 | 1,969,583,118.60 |
| 210101 | Үндсэн цалин | 1,595,932,957.30 | 1,743,072,112.60 |
| 210102 | Нэмэгдэл | - | 177,653,806.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,005,000.00 | 11,204,500.00 |
| 210104 | Урамшуулал | - | 37,652,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,072,112.98 | 48,010,639.98 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,144,000.00 | 3,238,506.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,928,112.98 | 44,772,133.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,582,594.39 | 109,565,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,829,564.39 | 20,988,623.48 |
| 210302 | Түлш, халаалт | 40,359,850.00 | 78,742,390.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,393,180.00 | 9,834,286.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,280,980.82 | 48,263,107.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 421,300.00 | 2,613,330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,507,644.00 | 32,812,478.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,372,036.82 | 2,902,199.60 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,450,000.00 | 8,730,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,080,000.00 | 1,045,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 450,000.00 | 160,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 77,549,750.00 | 114,908,457.00 |
| 210502 | Хоол, хүнс | 76,549,750.00 | 114,908,457.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 91,804,000.00 | 73,140,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 91,804,000.00 | 73,140,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 5,650,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 5,650,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,195,545.00 | 27,652,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,584,000.00 | 20,188,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,262,305.00 | 6,526,150.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 429,000.00 | 429,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 121,200.00 | 108,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | 799,040.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,691,000.00 | 39,275,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,691,000.00 | 39,275,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **50,646,553.51** | **16,680,881.82** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,995,000.00 | 7,179,200.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 5,039,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,995,000.00 | 2,140,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,651,553.51 | 9,501,681.82 |
| 213301 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,651,553.51 | 8,167,211.82 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,334,470.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **665,573,641.94** | **675,880,564.00** | **1,973,960,193.85** | **3,315,414,399.79** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 138,848,074.39 | 138,848,074.39 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **665,573,641.94** | **675,880,564.00** | **2,112,808,268.24** | **3,454,262,474.18** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 32,814,585.00 | 32,814,585.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **665,573,641.94** | **675,880,564.00** | **2,145,622,853.24** | **3,487,077,059.18** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (32,814,585.00) | - | (32,814,585.00) |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 224,591,571.30 | 224,591,571.30 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **665,573,641.94** | **643,065,979.00** | **2,370,214,424.54** | **3,678,854,045.48** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,315,669,800.00 | 2,307,502,588.18 | 8,167,211.82 | 99.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,315,669,800.00 | 2,307,502,588.18 | 8,167,211.82 | 99.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,309,462,600.00 | 2,301,295,388.18 | 8,167,211.82 | 99.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,966,816,400.00 | 1,965,598,418.60 | 1,217,981.40 | 99.9 |
| 210101 | Үндсэн цалин | 1,325,426,200.00 | 1,743,072,112.60 | (417,645,912.60) | 131.5 |
| 210102 | Нэмэгдэл | 585,366,000.00 | 173,669,106.00 | 411,696,894.00 | 29.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,371,400.00 | 11,204,500.00 | 7,166,900.00 | 61.0 |
| 210104 | Урамшуулал | 37,652,800.00 | 37,652,700.00 | 100.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,590,400.00 | 48,010,639.98 | 1,579,760.02 | 96.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,407,300.00 | 3,238,506.19 | 7,168,793.81 | 31.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,760,500.00 | - | 2,760,500.00 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36,422,600.00 | 44,772,133.79 | (8,349,533.79) | 122.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 109,565,300.00 | 109,565,300.00 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,684,400.00 | 20,988,623.48 | (4,304,223.48) | 125.8 |
| 210302 | Түлш, халаалт | 80,155,900.00 | 78,742,390.52 | 1,413,509.48 | 98.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,725,000.00 | 9,834,286.00 | 2,890,714.00 | 77.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,343,800.00 | 3,670,629.60 | 1,673,170.40 | 68.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 647,900.00 | 463,330.00 | 184,570.00 | 71.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,002,200.00 | 2,002,199.60 | 0.40 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,075,500.00 | 1,045,000.00 | 30,500.00 | 97.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,618,200.00 | 160,100.00 | 1,458,100.00 | 9.9 |
| **2105** | **Нормативт зардал** | 71,100,700.00 | 71,100,700.00 | - | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 71,100,700.00 | 71,100,700.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 73,157,000.00 | 73,140,850.00 | 16,150.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 73,157,000.00 | 73,140,850.00 | 16,150.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,188,600.00 | 27,652,450.00 | 1,565,150.00 | 94.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,188,600.00 | 20,188,600.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 9,038,900.00 | 6,526,150.00 | 2,512,750.00 | 72.2 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 429,000.00 | 429,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 108,700.00 | 108,700.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 799,100.00 | 400,000.00 | 399,100.00 | 50.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,671,400.00 | 2,556,400.00 | 2,115,000.00 | 54.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,671,400.00 | 2,556,400.00 | 2,115,000.00 | 54.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,207,200.00 | 6,207,200.00 | - | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,207,200.00 | 6,207,200.00 | - | 100.0 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 5,039,100.00 | 5,039,100.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,168,100.00 | 1,168,100.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,318,773,400.00 | 2,307,502,588.18 | 11,270,811.82 | 99.5 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,317,426,700.00 | 2,307,502,588.18 | 9,924,111.82 | 99.6 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,317,426,700.00 | 2,307,502,588.18 | 9,924,111.82 | 99.6 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,346,700.00 | - | 1,346,700.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,346,700.00 | - | 1,346,700.00 | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 67 | 55 | 12 | 82.1 |
| 620,001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0 |
| 620,002 | Гүйцэтгэх ажилтан | 65 | 52 | 12 | 81 |
| 620,003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | - | 100 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **137,060,205.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **137,060,205.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 134,753,735.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,984,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 3,984,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,592,478.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,150,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,812,478.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 8,730,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,807,757.00 |
| 210502 | Хоол, хүнс | 43,807,757.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,650,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 5,650,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 36,718,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,718,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 972,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 972,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 972,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,334,470.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,334,470.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 137,060,205.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 137,060,205.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 68,267,115.00 |

| | | |
|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,962,500.00 |
| 131105 | Бусад нэмэлт орлого | 8,830,590.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “..*гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах”* гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь үйл ажиллагааны зорилгоо: “*Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг гамшгаас хамгаалах, болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, гамшиг судлалыг хөгжүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, иргэдийг аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино”* гэж тодорхойлж, дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх, түүнд чиглэсэн сургалт, мэдээ мэдээллээр хангах;
- Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх, гамшиг ослын дуудлагаар ажиллах чадавхыг сайжруулах.

## 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 60,225.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 936,763.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 32,220.4 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 3,200.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 29,020.4 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хэвлэл мэдээллийн үйлчилгээг гэрээнд заагдсан хугацаанаас 1 сараар дутуу үзүүлсэн байхад төлбөр тооцоог 100 хувь шилжүүлж, 3,200.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна. | 1 | 3,200.0 | | | 1 | 3,200.0 | | | | | | |
| Засварын материалын зарцуулалт, ажлын гүйцэтгэлийг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байна | 1 | 15,800.0 | | | | | 1 | 15,800.0 | | | | |
| Цалингийн урьдчилгааг зарим хүмүүст өргөдөл зөвшөөрөлгүйгээр үндсэн цалингаас илүү дүнгээр хавтгайруулан олгож, бүрэн суутгаагүй авлагын үлдэгдэлтэй тайлагнасан байна. | 1 | 557.7 | | | | | 1 | 557.7 | | | | |
| Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын шийдвэрээр оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулахдаа тогтоосон хэмжээнээс үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн илүү олгосон байна. | 1 | 2,332.5 | | | | | 1 | 2,332.5 | | | | |
| Төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна. | 1 | 10,330.2 | | | | | 1 | 10,330.2 | | | | |
| **Дүн** | **5** | **32,220.4** | | | **1** | **3,200.0** | **4** | **29,020.4** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим дэлгүүрт байршсан бараа, мах, хүнсний ногоог бусад этгээдээс худалдан авсан байна. | 1 | 60,225.0 | | | 1 | 60,225.0 | | |
| Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий  орлогын 171,134.0 мянган төгрөг 7 гүйлгээ, зарлагын 104,447.9 мянган төгрөгийн 14 гүйлгээ, өмч, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 8 шийдвэрийг мэдээлээгүй байна. | 1 | 936,763.7 | | | | | 1 | 936,763.7 |
| **Нийт дүн** | **2** | **996,988.7** | | | **1** | 60,225.0 | **1** | 936,763.7 |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 46/А0270181 Улаанбаатар хот

НТАГ-2026/556/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Хэвлэл, мэдээллийн үйлчилгээг гэрээнд заагдсан хугацаанаас 1 сараар дутуу үзүүлж, тооцоо бодсон актаар 100 хувиар дүгнэн 3,200.000.00 (*гурван сая хоёр зуу*) төгрөгийг суутган тооцоогүй шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, *гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний биелэлт бүрэн хангаагүй, ажил гүйлгээг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга (Н.Мөнхбат), ахлах нягтлан бодогч (Н.Уянга) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Б.ТЭГШЛХАМ

1429990073